



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/56

Номгон

Шуурхай бүлэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай" 277 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын , Ерөнхий сайдын 2022 оны "Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх тухай" 09 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цас ихээр орж өвөлжилт хүндэрсэн зарим сумдын нөхцөл байдалд эрсдэлийн үнэлгээ хийх, сумын "Шуурхай штаб"-ын бүрэлдэхүүнийг мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах, шуурхай бүлгийн бүрэлдэхүүнийг томилсугай.


2.Шуурхай бүлгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хэрэгжүүлэх ажлын удирдамжийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Шуурхай бүлгийн бүрэлдэхүүний унаа, шатах тослох материалын зардал 1.280.300 (Нэг сая хоёр зуун наян мянга гурван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Сумдын онцгой комиссын үйл ажиллагааг чиглүүлж, удирдамжийн хэрэгжилтийг ханган, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА




Д.МӨНХСАЙХАН

642310137

D:\2023 он\захирамж-2023\Захирамж-2023 он.docx

Аймгийн Засаг даргын *А.Б.Б.* оны *01* дүгээр сарын
30-ны өдрийн *А.Б.Б.* дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт



**АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ШУУРХАЙ БҮЛЭГ**

1 дүгээр чиглэл: Өлзийт, Эрдэнэцогт, Баянхонгор сумын Шаргалжуут 8
дугаар баг хамрагдана.

Шуурхай бүлгийн ахлагч:

1. Б.Батсуурь

Гишүүд:

2. С.Тэгшбаяр

3. Л.Цэрмаа

4. Ж.Бат-золбоо

Жолооч:

5. Ш.Энэбиш

Аймгийн Онцгой комиссын орлогч дарга.

Хүнс хөдөө аж ахуйн газрын мэд үржлийн албаны
дарга.

Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн
технологийн хэлтсийн дарга.

Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын
хяналтын байцаагч, ахмад

Аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч

2 дугаар чиглэл: Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут сум хамрагдана.

Ажлын хэсгийн ахлагч:

1. У.Балжинням

Гишүүд:

2. Б.Мягмарсүрэн

3. Ц.Баяр-Өлзий

4. Т.Хишигбаатар

Жолооч:

5. М.Бат-Үзэсгэлэн

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга.

Онцгой комиссын нарийн бичгийн дарга. Дэд
хурандаа

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн мэдээлэл
үйлчилгээний хэлтсийн дарга.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын жолооч

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын
30-ны өдрийн А/ЭБ дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

УДИРДАМЖ

2023 оны 01 дүгээр сарын 30

Номгон

**Өвөлжилт хүндэрсэн зарим сумдад ажиллах
шуурхай бүлэг томилох тухай**

Нэг. Зорилго:

1.1. Өвөлжилт хүндэрч, цас ихээр орсон Галуут, Гурванбулаг, Заг, Жаргалант, Эрдэнэцогт, Өлзийт, Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багт ажиллаж, өвөлжилтийн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлэх, зудын эрсдэлийн үнэлгээ хийх, цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлуудыг тогтоож аймгийн Онцгой комисст танилцуулах.

Хоёр. Хугацаа, чиглэл

1 дүгээр ажлын хэсэг: Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар баг, Өлзийт, Эрдэнэцогт сумдад,

2 дугаар ажлын хэсэг: Галуут, Гурванбулаг, Заг, Жаргалант сумдад 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөс 2 дугаар сарын 1-ний өдрүүдэд нийт 3 хоног ажиллана.

Гурав. Хэрэгжүүлэх ажлын талаар:

2.1. Сумдын онцгой комисс болон “Зуд, өвөлжилт хүндэрсэн үед ажиллах Шуурхай штаб”-аас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй танилцаж, заавар, зөвлөмжөөр хангах;

2.2. Зудын эрсдэлийн үнэлгээ хийх,

2.3. Сумдын өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, худалдан авахад төсөвлөсөн төсөв, хуваарилалтад хяналт тавьж, зөвлөмжөөр хангах;

2.4. Тус аймгаас өөр аймгийн нутаг дэвсгэрт өвөлжиж байгаа болон гадны аймгаас дээрх сумдад отроор өвөлжиж байгаа айл өрх, хүн ам, малын тоо толгойн судалгаа мэдээллийг гаргах;

2.5. Малын зүй бус хорогдлын бодит мэдээг сум тус бүрээр гаргах;


2.6. Өвөлжилт хүндэрсэн сумдын малчдын хотонд ажиллаж, бэлтгэсэн өвс, тэжээлийн нөөц, хүрэлцээ хангамжтай газар дээр нь танилцах;

2.

2.7. Малчдаас эрүүл мэндийн болон бусад төрийн үйлчилгээг малчдын хотонд хүргэх талаар санал авч, нэгтгэх.

_____oOo_____

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дүгээр сарын
30-ны өдрийн 450 дугаар захирамжийн 3 дугаар
хавсралт



**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН
ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Автомашин ны марк	Явах чиглэл	Холын зай /км/	100 км- т/л/	Зарцуулах шатахуун	1 л шатахууны үнэ	Нийт
1	Ланд-76	1-р чиглэл	600	20	120	4130	495600
2	Ланд-76	2-р чиглэл	800	20	190	4130	784.700
Нийт дүн							1.280.300

оОо